

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ОРДНЫ МЭДЭЭЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР
ТӨААТҮГ-ЫН ДАРГА Б.ТУУЛ
ТАНАА

2020.03.13 № 06/824
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын /хуучин нэрээр/ 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын /хуучин нэрээр/ 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дарга Б.Туул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлан, тодруулгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ноос 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны Өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Б энд С аудит ХХК-ийн захирал Д.Дашхорлоо, чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг, ахлах аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах Ц.Дөлгөөн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго: Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь экологийн цэвэр бүтээгдэхүүн, ур чадвартай манлайлагч хүний нөөц, тохилог орчноор мэргэжлийн өндөр зэрэглэлийн үйлчилгээг зохион байгуулагч, төр засгийн хоол, үйлчилгээний тэргүүлэх чиглэлийн байгууллага болох зорилттойгоор Төрийн ордны зоогийн газар, Элит төв, Горхи амралт гэсэн 3 салбараар төрийн 3 өндөрлөг, тэднээр дамжин ирсэн зочид төлөөлөгчид, УИХ-ын гишүүд, төрийн албан хаагч, ажилтнуудад үйлчилдэг мэргэшсэн хамт олон байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн ордны зоогийн газрын үйл ажиллагаа
- Төрийн ордны зоогийн газрын буфет, кофе шопын үйл ажиллагаа
- Элит төвийн үйл ажиллагаа
- Горхи амралтын газрын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив ХХК-ийн пирамид болон Диамонд программ хангамж ашигладаг байна.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ны бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,805.0 сая төгрөгөөс тооцон 36.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.9 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, хуримтлагдсан ашиг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7.8	17.7	9.9
Авлага	0.9	18.4	17.5
Урьдчилгаа			
Бараа материал	394.6	389.6	-5.0
Үндсэн хөрөнгө	1,394.8	1,379.3	-15.5
Нийт хөрөнгө	1,798.1	1,805.0	6.9
Өр төлбөр	0.6	0.6	0
Эздийн өмч	1,797.5	1,804.4	6.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,798.1	1,805.0	6.9

Авлага дансны үлдэгдэл өссөн нь ажилчдад олгосон зээл, гэрээт ажлын үлдэгдэл тооцоо байгаагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь үндсэн борлуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр 16.4 сая төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн орлогын албан татварын тооцооллоор нэмэгдсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1,804.4 сая төгрөг болж 6.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь 2019 онд 1,650.5 сая төгрөгийн орлоготой, 1,635.5 сая төгрөгийн зардалтай, 15.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөжээ. 2019 оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2,040.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,033.1 сая төгрөгийн зардалтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 390.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж 6.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

2.10 АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 8.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0.8 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 6.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.5 сая төгрөгт албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Анхан шатны баримт болон дэмжин нотлох баримтгүйгээр 0.8 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд архи согтууруулах ундааны борлуулалтад ногдох 0.5 сая төгрөгийн Нийслэл хотын албан татварыг суутгаж, тайлагнаагүй байгаа нь Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 “Албан татвар суутгагч тухайн сард борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлж, тайланг батлагдсан маягтын дагуу дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд тушаана” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлж байна

Аудитаар илэрсэн 6.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын аудитаар доорх асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. 2019 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэгж хоолны орц, нормыг холбогдох сандартын дагуу нарийн тусгаагүй, 2020 онд нэгж хоолны өртгийг нийтийн хоолны жишиг стандартын дагуу нэмж шинэчлэл хийсэн хэрэгжилтийг хянах
2. Хангамжийн материал дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 333.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байгааг 2020 оны 2 дугаар улиралд шинэчилсэн Ритус ХХК-ийн Ноён программ нэвтрүүлэхдээ жагсаалтын дагуу ангилан бүртгэхээр төлөвлөсөн байна,
3. Хувь хүний орлогын албан татварын ТТ-12-т дутуу тайлагнасан 63.5 сая төгрөгийн татварыг залруулахаар аудитын хугацаанд татварын хэлтэст хүсэлт илгээсэн, татварын баталгаажуулалтыг дараагийн аудитаар авч үзэх

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 80 мэдээллийг хугацаанд нь, 55 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд 6.6 сая төгрөгийг дутуу тайлагнасан байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл: Холбогдох хууль зөрчигдөх, өр авлага буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх, 2020 оны 2 дугаар улиралд багтаан нөхөн тайлагнах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. 2020 оны 2 дугаар улиралд багтаан харьяалах нийгмийн даатгалын хэлтэст нөхөн тайлагнана.

3.2. Шилэн данстай холбоотой

3.2.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэлийг тайлагнахдаа хугацаа хоцорсон 55 мэдээлэлтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл : Холбогдох хууль зөрчигдөх, мэдээлэл буруу илэрхийлэгдэх

- 3.1.4 Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, тайлагналд хяналт тавьж ажиллах
- 3.2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Дараагийн тайлант хугацаанаас эхлэн холбогдох хуульд заасан хугацаанд тайлагнаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,827,147.12	17,746,287.50
1.1.2	Дансны авлага	700,000.00	18,400,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	211,325.16	0.00
1.1.6	Бараа материал	394,547,856.14	389,561,348.21
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	403,286,328.42	425,707,635.71
1.2.1	Үндсэн хөрөнгө	600,516,944.82	585,446,726.28
1.2.2	Биет бус хөрөнгө	794,276,340.29	793,852,461.89
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,394,793,285.11	1,379,299,188.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,798,079,613.53	1,805,006,823.88
2.1.1.3	Татварын өр	546,452.42	605,432.16
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн	546,452.42	605,432.16
2.2	Өр төлбөрийн нийт дүн	546,452.42	605,432.16
2.3.1	Төрийн өмч	180,229,662.66	180,229,662.66
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	214,694,634.58	214,694,634.58
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний	219,348,820.17	219,348,820.17
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	794,821,700.00	794,821,700.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	388,438,343.70	395,306,574.31
2.3.20	Эздийн өмчийн дүн	1,797,533,161.11	1,804,401,391.72
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,798,079,613.53	1,805,006,823.88

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,615,880,501.36	2,040,880,270.69
2	Борлуулалтын өртөг	816,147,623.30	997,004,434.86
3	Нийт ашиг (алдагдал)	799,732,878.06	1,043,875,835.83
9	Борлуулалт, маркетингийн зардал	625,417,046.71	802,870,326.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	163,872,192.46	210,513,957.17
12	Бусад зардал	0.00	22,860,759.89
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,385.99	574.91
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	10,445,024.88	7,631,367.35
19	Орлогын татварын зардал	1,044,502.09	763,136.74
20	Татварын дараах ашиг (алдагдал)	9,400,522.79	6,868,230.61
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	9,400,522.79	6,868,230.61
24	Орлогын нийт дүн	9,400,522.79	6,868,230.61

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,643,020,921.36	2,109,519,666.69
1.1.1	Бараа борлуулсан,	1,630,445,421.36	2,077,375,630.69
1.1.4	Буцаан авсан албан	0.00	5,210.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,575,500.00	32,138,826.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,647,339,625.94	2,089,551,101.22
1.2.1	Ажиллагчдад төлсөн	414,473,078.00	516,031,952.84
1.2.2	Нийгмийн даатгалын	100,700,000.00	119,220,400.00
1.2.3	Бараа материал	966,295,354.00	1,216,531,519.00
1.2.4	Ашиглалтын зардалд	72,655,267.00	61,109,482.00
1.2.5	Түлш, шатахуун,	45,271,894.00	80,795,865.00
1.2.7	Татварын	14,720,000.00	60,638,089.00
1.2.8	Даатгалын төлбөрт	0.00	315,940.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,224,032.94	34,907,853.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны	4,318,704.58	19,968,565.47
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	10,050,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж	0.00	10,050,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл	0.00	(10,050,000.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,605.89	652.87
3.1.4	Валютын ханшийн	1,605.89	652.87
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	219.90	77.96
3.2.5	Валютын ханшийн	219.90	77.96
3.3	Санхүүгийн үйл	1,385.99	574.91
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,317,318.59)	9,919,140.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах	12,144,465.71	7,827,147.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах	7,827,147.12	17,746,287.50

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	379,037,820.91	795,354,076.84
Залруулсан үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	379,037,820.91	795,354,076.84
Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	200,070,561.48	792,708,000.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	0.00	9,400,522.79	9,400,522.79
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	219,348,820.17	794,821,700.00	388,438,343.70	1,797,533,161.11
Залруулсан үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	219,348,820.17	794,821,700.00	388,438,343.70	1,797,533,161.11
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	0.00	6,868,230.61	6,868,230.61
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	219,348,820.17	794,821,700.00	395,306,574.31	1,804,401,391.72

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.10	Аудитын нэр: Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код: САГ-2020/20/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Дэмжин нотлогдох баримтгүйгээр тайлант үеийн зардалд бүртгэсэн	0.8	Акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
2	Нийгмийн даатгалын тайланд дутуу илэрхийлсэн	6.7	Зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
3	Нийслэл хотын албан татвар аваагүй	0.5	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
	Нийт	8.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 18 № 02/59

Улаанбаатар хот

С АТ- 20 20 / 20 / С Т А - Т О Ч И Г

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ / хуучин нэрээр/- ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримт болон дэмжин нотлох баримтгүйгээр 846,500,00 төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. , 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн нийт 846,500.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний Аудитын газрын Төрийн сан банкин дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 5 дугаар сарын 10 дотор төвлөрүүлж, улсын төсвийн орлого болгох,
2. Тогтоосон төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 15 өдрийн дотор Үндэсний Аудитын газар ирүүлэхийг Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дарга Б.Туул, ерөнхий нягтлан бодогч Б.Батжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР Ц.НАВАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

"Б ЭНД С АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР Д.ЗАЯАЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨР ЗАСГИЙН АМРАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЦОГЦОЛБОР ТӨААТҮГ ДАРГА

ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Б.ТУУЛ
Б.БАТЖАРГАЛ

Акт, албан шаардлага, биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь залах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Richie_Kherep\Akt\2020\0317SAG2 Docx

001090148



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 18 № 02/126
С.ЯТ- 2020/20/СТЯ-ТӨЧГ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ / Хуучин нэрээр/- ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд архи согтууруулах ундааны борлуулалтад ногдох 510,991.83 төгрөгийн Нийслэл хотын албан татварыг суутгаж, тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1, 14 дүгээр зүйл 14.4.1 аж ахуйн бүх ажил, гүйлгээг, 14.4.3 бүх өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана, 18 дугаар зүйлийн 18.1 болон Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 “Албан татвар суутгагч тухайн сард борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлж, тайланг батлагдсан маягтын дагуу дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд тушаана” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн тайланг иж бүрэн тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дарга Б.Туул , ерөнхий нягтлан бодогч Б.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Б.СЭРЖМЯДАГ
“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР *Д.ЗАЯАЖАРГАЛ*

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨР ЗАСГИЙН АМРАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЦОГЦОЛБОР ТӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ТУУЛ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Б.БАТЖАРГАЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харгууцагч албан тушаалтанд харгууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

